



**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 09

Өмнөдэлгэр сум


**Гурванбаян тосгоны хүүхэд хамгааллын
хамтарсан багийн бүрэлдэхүүнийг
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Аравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хамгаалах чиг үүрэг бүхий хамтарсан багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хамтарсан багийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, багийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх, багаа тогтвортой ажиллах нөхцөлийг хангаж ажиллахыг тосгоны Захирагч (Ж. Энххуяг)-д, ажлыг хагас, бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлж, тайланг сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлж ажиллахыг тосгоны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Г.Номин-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА




Ц. ПҮРЭВДОРЖ

D.disc /alban bichig/ ITH togtool

232600122

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны
04 дугаар сарын 29-ны өдрийн Аравдугаар
хуралдааны 07 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт



ГУРВАНБАЯН ТОСГОНЫ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Захирагч
Нарийн бичгийн дарга:	Нийгмийн ажилтан
Гишүүдэд:	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	ЕБС-ийн Нийгмийн ажилтан
	Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
	Соёлын төвийн дарга
	Цэцэрлэгийн эрхлэгч
	ЕБС-ийн захирал
	Хэсгийн төлөөлөгч